



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 14 дүгээр зүйлийн 14.8.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 13 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний үлгэрчилсэн загвар”-ын 2.1.2 дахь хэсгийн “Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.10-т заасан өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх төлбөрийг нь төр хариуцах тусламж, үйлчилгээнд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 70 хувийг сар бүрийн 11-ний дотор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид олгон, үлдэгдэл 30 хувийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн бүтэн жилийн гэрээний шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн үнэлгээнд үндэслэн олгох эсэхийг шийдвэрлэх” гэсэн заалтын “70 хувийг” гэснийг “80 хувийг” гэж, “30 хувийг” гэснийг “20 хувийг” гэж, “бүтэн жилийн” гэснийг “сар бүрийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба (Л.Номин)-нд даалгасугай.

ДАРГА



С.ЭНХБОЛД

